



ИРГЭНИЙ НИСЭХИЙН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2023 оны 02 сарын 14 өдөр

Дугаар 4/16

Улаанбаатар хот

Үнэлгээний баг байгуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Монгол Улсын Засгийн газрын Журам шинэчлэн батлах тухай 218 дугаар тогтоол, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын даргын Аргачлал, загвар батлах тухай 100 дугаар тушаал, Иргэний нисэхийн ерөнхий газрын Хөдөлмөрийн дотоод журмын 10.6 дахь заалт, Иргэний нисэхийн ерөнхий газрын ажилтнуудын гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэлийг үнэлэх журмыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Иргэний нисэхийн ерөнхий газрын дотоод зохион байгуулалтын нэгжийн ажилтнуудын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг үнэлж, дүгнэх үнэлгээний багийн бүрэлдэхүүнийг хавсралтаар байгуулсугай.

2. Ажилтнуудын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөний хэрэгжилтийг холбогдох хууль тогтоомж, эрх зүйн акт болон байгууллагын дотоод журамд заасны дагуу үнэлж, үнэлгээний саналыг 2023 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн дотор багтаан Иргэний нисэхийн ерөнхий газрын даргад танилцуулахыг Үнэлгээний баг (Т.Батжаргал)-т үүрэг болгосугай.

3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Дотоод аудитын алба (Б.Мөнх-Очир)-нд даалгасугай.

ДАРГА



Ч.МӨНХТУЯА

Иргэний нисэхийн ерөнхий газрын даргын
2023 оны 10 дугаар сарын 23-ний өдрийн
10/23 дугаар тушаалын хавсралт



ҮНЭЛГЭЭНИЙ БАГИЙН БҮРЭЛДЭХҮҮН

Үнэлгээний багийн ахлагч:

Т.Батжаргал
(Захиргаа, удирдлагын газрын дарга)

Гишүүд:

Ч.Одгэрэл
(Агаарын навигаци, нисэх буудлын бодлого
зохицуулалтын газрын дарга)

Г.Батбаяр
(Агаарын тээврийн бодлого, зохицуулалтын
газрын дарга)

Д.Хатанбаатар
(Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга)

П.Ариунболд
(Хууль, эрх зүй, дүрмийн боловсруулалтын
газрын дарга)

Г.Амарцэцэг
(Нисэхийн аюулгүй ажиллагааны хяналт,
зохицуулалтын албаны дэд дарга)

Ө.Мөнгөнжигүүр
(Дотоод аудитын албаны менежер)

Ц.Батчимэг
(Захиргаа, удирдлагын газрын ахлах
мэргэжилтэн)

Нарийн бичгийн дарга:

Ч.Энхтүвшин
(Захиргаа, удирдлагын газрын
мэргэжилтэн)